

ХЭРЭГЛЭХ ЗААВАР: ХЭРЭГЛЭГЧИД ЭД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Вазомаг 250 мг хатуу бүрээст

Мелдони

Танд зориулсан чухал мэдээлэл агуулсан тул эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө зааврыг сайтар уншина уу.

- Зааврыг хадгал. Танд дахин унших хэрэг гарч болно.
- Хэрэв танд ямар нэг асуулт байвал эмч, эм зүйчээс лавлана уу.
- Энэ эмийг зөвхөн таньд зориулан жоронд бичсэн. Бусдад дамжуулж болохгүй. Хэдийгээр ижил шинж тэмдэг илэрсэн ч бусдад аюултай нөлөө үзүүлж болзошгүй.
- Хэрэв танд аль нэг гаж нөлөө илэрвэл эмч, эм зүйчид мэдэгдэнэ. Үүнд зааварт тусгагдаагүй гаж нөлөө байж болно. 4 хэсгийг үзнэ үү.

Агуулга

1. Вазомаг гэж юу вэ, юунд хэрэглэх вэ
2. Вазомаг хэрэглэхийн өмнө мэдвэл зохих зүйлс
3. Вазомаг хэрхэн хэрэглэх вэ
4. Боломжит гаж нөлөө
5. Вазомаг хэрхэн хадгалах вэ
6. Бусад мэдээлэл

1. ВАЗОМАГ ГЭЖ ЮУ ВЭ, ЮУНД ХЭРЭГЛЭДЭГ ВЭ

Вазомаг бие махбодын энергийн солилцоонд зерэгээр нөлөөлөн төв мэдрэлийн системийг дунд зэрэг идэвхжүүлдэг.

Ишемий нөхцөлд (эдийн хүчилтөрөгчийн дутагдал), вазомаг эсийн хүчилтөрөгчийн хүргэлт, хэрэглээ хоёрын хооронд энергийн тэнцвэрийг сэргээх, энерги болгох хүчилтөрөгчийн хэрэглээ бага шаарддаг бодисын солилцоог идэвхжүүлдэг. Энэ эм нь судас тэлснээр эдийн цусны эргэлтийг сайжруулна.

Вазомаг хүчилтөрөгчийн дутагдал, ишеми нөхцөлд зүрх хамгаалах үйлдлийг ихэсгэнэ. Вазомаг зүрхний бахтай өвчтөний зүрхний бахын хөдлөлийн давтамжийг бууруулж (зүрхээр хүчтэй өвдөх), биеийн хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлийн. Зүрхний дутагдал

MPL1.135.099/1.U

Үүссэн тохиолдолд зүрхний булчингийн дамжуулалтыг ихэсгэн биеийн чадварыг нэмэгдүүлнэ.

Тархины судасны архаг, хурц ишемийн эмгэгийн үед Вазомаг ишемийн бүсд цусны урсгалыг сайжруулах, дахин хувиарлалтыг нэмэгдүүлнэ.

Вазомагын ТМС-д үзүүлсэн нөлөөний дүнд санах ой, чадвар, хөдөлгөөн зохицуулалт сайжирна.

Вазомаг-г:

- Зүрх судасны системийн хосолсон эмчилгээнд: зүрхний бахын тогтвортойлтуулалт, зүрхний архаг эмгэг (NYHA I-III үйл ажиллагааны анги), зүрхний булчингийн ишеми (зүрхний булчингийн үрэвслийн бус эмгэг), зүрхний булчингийн дараах сэргэлтийн үед;
- Тархины цусны эргэлтийн архаг, хурц ишемийн хосолсон эмчилгээнд;
- Толгойны гэмтэл, тархины цусны эргэлтийн эмгэгийн дараах сэргэлтийн үеийн хосолсон эмчилгээнд;
- Бие махбодын, сэтгэл хөдлөлийн хэт ачааллын гүйцэтгэл буурсан үед тус тус хэрэглэнэ.

2. ВАЗОМАГ ХЭРЭГЛЭХИЙН ӨМНӨ МЭДВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛС

Дараах нөхцөлд Вазомаг хэрэглэхгүй:

- хэрэв та мелдони болон вазомагын найрлаг дах бусад нэгдэлд харшилтай (хэт мэдрэг) бол
- хэрэв та элэгний хатууралтай / бөөрний эмгэгтэй бол .
- хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл бол хориглоно.

Анхааруулга, сэрэмжлүүлэг

Хэрэв та элэг/ бөөрний эмгэгтэй бол эмчид мэдэгдэх ёстой, учир нь таны элэг/ бөөрний үйл ажиллагааны идэвхийг хянах шаардлагатай.

Вазомаг эмийг 18-с доош насны хүүхдэд үр дүн, аюулгүй хэрэглээ судлагдаагүй тул хэрэглэхийг хориглоно.

Вазомаг бусад эмийн харилцааны нөлөө

Хэрэв та жороор олгодог өөр төрлийн эмийн бэлдмэл хэрэглэж буй бол эмч, эм зүйчид мэдэгдэх ёстой.

MPL1.135.099/1.U

Мелдони агуулсан бусад эмийн бэлдмэлүүдтэй хамт хэрэглэхгүй (гаж нөлөөний эрсдлийг нэмэгдүүлнэ).

Вазомаг эмийг антиангинал эмүүд, антикоагулянтууд (цусны эргэлтэнд нөлөөлдөг эм), антиагрегант (тромбоцит эсийн наалдуулах урвалыг саатуулна), хэм алдалтын эсрэг эмүүд, зүрхний гликозидууд, шээс хөөх эмүүд (шээсний ялгаралтыг нэмэгдүүлдэг эм}, бичил эргэлтийг сайжруулах эмүүдтэй (жижиг судасны цусны эргэлтийг сайжруулна) хамт хэрэглэж болно.

Вазомаг глицерилнитрат, нифедипин, бета-адреноблокаторууд, даралт бууруулах эмүүд, захын судас тэлэх эмүүдийн үйлдлийг хүчжүүлнэ.

Жирэмсэн, хөхүүл

Вазомаг эмийг жирэмсэн, хөхүүл үед хэрэглэхийг хориглоно.

Жолоо барих, механизмтай ажиллах

Вазомаг эмийн жолоо барих, механизмтай ажиллах чадварт үзүүлэх нөлөөний талаарх үзүүлэлт байхгүй.

3. ВАЗОМАГ ЭМИЙГ ХЭРХЭН ХЭРЭГЛЭХ ВЭ

Вазомаг эмийг эмчийн заавраар хэрэглэнэ. Хэрэв та итгэхгүй байгаа бол эмч, эм зүйчтэй хамт шалгаж болно. Бүрээсийг усаар даруулж ууна.

Эмч эмчилгээний тун, үргэлжлэх хугацааг тогтооно.

Насанд хүрэгчидийн хоногийн тун 500-1000 мг. Хоногийн 500 мг тунг (2 бүрээс) өглөө нэг удаа ууна. Боломжит үр дүн харуулахын тулд хоногийн 1000мг тунг (4 бүрээс) хоёр хуваан өдрийн эхний хагасд хоёр удаа ууна. Зүрх судасны эмгэг, тархины цусны эргэлтийн архаг, хурц эмгэгийн эмчилгээ 4-6 долоо хоног хэрэглэнэ. Курс эмчилгээ бие махбодын болон сэтгэл санааны хэт ачааллын үед 10-14 хоног байна.

Хэрэв та Вазомаг эмийг хэтрүүлэн хэрэглэвэл

Тун хэтэрсэн тохиолдолд цусны даралт буурах, толгой өвдөх, толгой эргэх, зүрх судасны үйл ажиллагаа хурдасна. Хэрэв та Вазомаг эмийг хэт ихээр хэрэглэсэн бол яаралтай эмчид мэдэгдэнэ!

Хэрэв та Вазомаг эмийн хэрэглээг мартсан бол

Хэрэв тогтмол тунгаар хэрэглээгүй бол аль болох хурдан тунгаа уух ба гэхдээ хоногийн тунг хэтрүүлэн хэрэглэхгүй.

Мартсан тунг давхарлан ууж болохгүй.

MPL1.135.099/1.U

Хэрэв та Вазомаг эмийн хэрэглээг зогсоосон бол
Хэрэв танд эмийн талаар асуулт байвал эмч, эм зүйчээс лавлана уу.

4. БОЛОМЖИТ ГАЖ НӨЛӨӨ

Гаж нөлөөний давтамжийг

Маш элбэг – 10 өвчтөнд 1-с их

Элбэг – 100-т 1 ба 100 өвчтөнд 1-с их

Цөөн – 100-д 1, гэхдээ 1000 өвчтөнд 1-с их

Ховор – 1000-д 1 гэхдээ 10000 өвчтөнд 1-с их

Маш ховор - 10000 өвчтөнд 1.

Бүх эмийн адил Вазомаг бүх өвчтөнд биш ч цөөн тоогоор гаж нөлөө илрэнэ.

Элбэг – толгой өвдөх, арьсны харшлын урвал (арьс улайх, чонон хөрвөс, загатнаа),
ходоодны хямрал (дотор муухайрах, ходоод хатуу оргих).

Ховор – цусны даралт буурах.

Маш ховор – тахикарди.

Эзинофили түүний хэмжээ илрэлийн давтамжийг тооцоход хангалтгүй. Харшлын үед
эмийн хэрэглээг зогсоон эмчтэй зөвлөлдөнө. Хэрэв танд ямар нэг гаж нөлөө илэрвэл
эмч, эм зүйчид мэдэгдэнэ. Зааварт тусгагдаагүй гаж нөлөө байж болно.

5. ВАЗОМАГ ХЭРХЭН ХАДГАЛАХ

25°C ихгүй хэмд хадгална. Гэрлийн тусгал, чийгнээс хамгаалан өөрийн саванд
хадгална.

Эмийг хүүхэд хүрэхгүй газарт хадгална.

Цаасан хайрцагт заасан хугацаа дууссан бэлдмэлийг хэрэглэхгүй.

Үүнд дуусах хугацааны сар, өдрийг бичсэн байна.

Үлдсэн хэсгийг ахуйн хог хаягдал, бохир усанд бүү устга. Удаан хугацаанд хэрэглээгүй
эмийг хэрхэн устгах талаар эм зүйчээс асуу.

6. БУСАД МЭДЭЭЛЭЛ**Вазомаг найрлага**

Идэвхтэй нэгдэл нь мелдони.

Бүрээс бүрд мелдоны дигидрат 250 мг агуулна.

Бусад найрлагад төмсний цардуул, цахиурын коллоид анgidroz, кальцын стеарат.

Бүрээсийн найрлагад: желатин, титаны давхар исэл.

MPL1.135.099/1.U

Вазомаг дурслэл, савалт

Блистерт 10 бүрээс.

4 бистерийг (40 бүрээс) хэрэглэх зааврын хамт цаасан хайрцагт савлана.

Бүх савлагагаа худалдаанд нийлүүлэгдээгүй байж болно.

Маркетингийн зөвшөөрөл эзэмшигч ба үйлдвэрлэгч

Joint-Stock Company "Olainfarm"

5 Rupnicu Street, Olaine, LV 2114

Latvia